

хариуцлагад татагдсан буюу шийтгэгдсэн бол уг хэргийг шуун таслах буюу таслан шийдвэрлэх тогтоолыг гуйцэтгэх хуртэл шилжуулэн өгөхийг хойшлуулж болно.

2. Хэрэв шилжуулэн өгөхийг хойшлуулах нь хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусахад хургэх буюу шилжуулэн өгвөл зохих этгээдийн хэргийг байцаан бурдуулэхэд ноцтой хохирол учруулахаар байвал уг этгээдийг Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн ундэслэл бүхий хусэлтийн дагуу хэргийг таслан шийдвэрлуулэх зорилгоор тур хугацаанд шилжуулэн өгч болно. Шилжуулэн өгөхийг хусэж байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээд уг гэмт этгээдийг шилжуулэн авсан өдрөөс хойш гурван сараас хэтруулэлгүйгээр туунийг буцаан шилжуулэх бөгөөд хэрэв шаардлагатай бол энэ хугацааг сунгана*

Наян тавдугаар зүйл

Шилжуулэн өгөх тухай хэд хэдэн
улсын шаардлага

Хэрэв шийтгэгдэх нэг буюу хэдэн янзын гэмт хэрэг үйлдсэний улмаас шилжуулэн өгөх тухай шаардлагыг хэд хэдэн улс тавивал уг шаардлагыг хулзэн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээд шилжуулэн өгвөл зохих этгээдийн аль улсын харьяат буюу гэмт хэрэг хаана үйлдсэн болон уг хэргийн хунд хөнгөнийг харгалзан аль шаардлагыг хангахаа өөрөө шийдвэрлэнэ.

Наян зургадугаар зүйл

Шилжуулэн өгсөн этгээдийг хэрэгт
холбогд.уулах хязгаар

I. Шилжуулэн өгсөн этгээдийг шилжуулэн өгөх ш;- х шаардлага-
гыг хулзэн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн
гуйгээр шилжуулэн өгөхийн өмнө үйлдсэн буюу шил
шаардлагад тодорхойлогдоогүй гэмт хэрэгт холбогдуулан татах,
шийтгэх, гурав дахь улсад шилжуулж болохгүй.